

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 1 дүүгэр
сарын 29-ны өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Тогтоолын хэрэгжилтийг түдгэлзүүлэх тухай

“Монад” ХХК нийтэд санал болгож үнэт цаасаа гаргахаар ирүүлсэн хүсэлтийг Хороо хэлэлцээд 2008 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 142 тоот тогтоолоор шийдвэрлэснээс хойш анхдагч зах зээлийн арилжаа эхлэлгүйгээр хугацаа өнгөрсөн, хүсэлт ирүүлэх үед Хороонд бүрдүүлэн өгсөн тус компанийн санхүүгийн тайлан болон бусад баримт материалуудын танилцуулга, тоон үзүүлэлтүүд өөрчлөгдсөн, үнэт цаас гаргах замаар бусдаас татсан хөрөнгөөр санхүүжүүлэхээр тооцож боловсруулсан төслийн үндэслэл, тооцоолол өөрчлөгдөх нөхцөл байдал үүссэн. Иймд хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хүргэх танилцуулга мэдээлэл бодитой бус байж болзошгүй нөхцөл үүссэн, улмаар санхүү эдийн засгийн хямрал болон хөрөнгийн зах зээлийн өнөөдрийн байдлаас үзвэл уг үнэт цаас гаргах үйл ажиллагаа амжилттай явагдахгүй байх магадлалтай байгаа тул Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монад” ХХК-ийн нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 142 дугаар тогтоолын хэрэгжилтийг 2009 оны 6 дугаар сарын 29-ны өдөр хүртэл түдгэлзүүлсүгэй.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ